

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2019 ОНЫ 7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2019.08.05

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар**

Ардын хувьсгалын 98 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 88 жилийн ой, Атар газар эзэмшсэний 60 жилийн ойн үндэсний их баяр наадмыг энэ сарын 4, 5-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлээ. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд оролцсон 189 унаач хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавьж 17 суманд чиглэл өгч ажиллалаа. Мөн Тулгар төрийн 2228 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 813 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 108 жилийн ой, Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын 98 жилийн ой, Атар газар эзэмшсний 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын аж үйлдвэр, боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, барилга, төр захиргаа, хууль эрх зүй болон бусад салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан иргэдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 127 дугаар зарлигаар шагнагдсан тус аймгийн харъяат иргэдийн шагнал гардуулах ёслолын арга хэмжээг 7-р сарын 9-ний өдөр зохион байгууллаа. Зарлигаар Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 6, Цэргийн гавьяаны одонгоор 1, Алтан гадас одонгоор 56, Хөдөлмөрийн хүндэт медалиар 23 иргэн шагнагдсан байна.

Сэлэнгэ аймаг, ОХУ-ын Буриад Улсын хилийн районуудтай хийсэн найрсаг хамтын ажиллагааны хүрээнд уламжлалт "Эв мод"-ны наадмыг 7-р сарын 18, 19-ны өдрүүдэд Алтанбулаг суманд зохион байгууллаа. Наадмын хүрээнд буриад сурын харваа, 3 жинд үндэсний бөхийн барилдаан, хоёр улсын дизайнаруудын үндэсний болон гоёлын хувцасны загвар, Ардын дуу бүжгийн "Сэлэнгийн долгио", дуу бүжгийн "Мөнгөн хараа" чуулга, Буриад Улсын уран бүтээлчдийн урлагийн тоглолтыг толилууллаа. Энэ жилийн "Эв мод"-ны наадмын онцлог нь Алтанбулаг сумын түүхт 290 жилийн ойтой давхцсанаараа онцлог байсан бөгөөд ОХУ-ын Буриад Улсын Хиагтын аймаг өргөн бүрэлдэхүүнтэйгээр ирж оролцлоо. Эв мод"-ны баяр наадмын үеэр Сайхан сумын "Хөтөл жимсгэнэ" ХХК, Алтанбулаг сумын "Борлбс милко" сүү цагаан идээ боловсруулах цех, Мандал сумын "Зүүнхараа кашмер", "Чансаа гутлын цех", Сүхбаатар сумын "Аж богд оёдлын цех", "Буянхишиг" талхан цех", Шаамар сумын иргэн Б.Баяраа нар өөрсдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа гаргаж, 2 сая төгрөгний борлуулалт хийн үйл ажиллагааг нь сурталчилан ажиллалаа.

ADRA Олон Улсын байгууллага, Германы эдийн засгийн яамны санхүүжилтээр хэрэгжиж буй "Органик хөдөө аж ахуйн түншлэл" төслийн хүрээнд тус аймгийн 11 сумын 31 хоршоо, 912 ногоочинг хамруулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэгчид тус аймагт ажиллаж, Орхон Ерөө Хангай үүлдрийн хонийг үржүүлэх, хамгаалах мах, ноосны чанарыг нэмэгдүүлж, малчдын ашиг орлогыг дээшлүүлэх, ногоочдын борлуулалтыг дэмжихэд хамтран ажиллах саналыг солилцлоо.

Сэлэнгэ аймаг халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэг оношилгоог нийт сум, тосгодыг хамруулан зохион байгуулж, хүн ардынхаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд онцгой анхааран ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг болоод сумдын Эрүүл мэндийн төвүүдийг зөөврийн эхо аппарат, түргэн тусламжийн авто машин, хэрэгцээт техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд аймгийн Засаг даргаас Алтанбулаг сумын түүхт ойг тохиолдуулан сумын Эрүүл мэндийн төвд зориулалтын 13 ширхэг шинэ орыг хүлээлгэн өгч, парк шинэчлэлтэд нь дэмжлэг үзүүлээ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас 21 аймгийн ЗДТГ-ын дарга, сумдын ЗДТГ-ын дарга, төрийн захиргаа, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтнүүдэд МУ-ын Үндсэн Хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөлд иргэдийг мэдээллээр хангаж ажиллах "СУРГАГЧ БАГШ" бэлтгэх онлайн сургалтыг 7 дугаар сарын 16-н зохион байгууллаа.

Олон Улсын түвшинд уламжлал болон зохион байгуулагдсан "Торгоны зам" авто ралли тэмцээнд оролцох тамирчдыг ОХУ-аас Монгол Улсын Алтанбулаг хилийн боомтоор дамжин өнгөрөх үеийн хамгаалалт, зохицуулалтанд тус аймгийн Цагдаагийн газрын 120, төрийн болон төрийн бус байгууллагуудын 305 ажилтан, албан хаагчид хамтран үүрэг гүйцэтгэсэн. Тус хилийн боомтоор "Торгоны зам" олон улсын авто ралли тэмцээний 38 орны 945 иргэн, 337 тээврийн хэрэгсэл, 4 онгоц нэвтэрч, хариуцсан нутаг дэвсгэрээр дамжин өнгөрсөн бөгөөд Сайхан сумын Номгон 3 дугаар багийн нутаг дэвсгэрт уралдаан зохион байгуулагдах үеийн хамгаалалтыг зохион байгууллаа.

### **Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар**

Аймгийн Онцгой байдлын газраас усны осол, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээг 07 дугаар сарын 01-ний өдрөөс 31-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж байна. Арга хэмжээний хүрээнд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сумд дахь Гал түймэр унтраах, аврах ангиуд, Эрэн хайх аврах ангийн бүрэлдэхүүн өдөр бүр 10:30-20:30 цагийн хооронд Орхон, Хараа, Ерөө голуудад завьтай болон явган эргүүлийг тогтмол хийж, голын эрэг дагуу амарч зугаалж явсан 4483 автомашинтай, 9792 том хүн, 1623 хүүхдэд гол мөрний усанд осолдохоос урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлгийг хүргэж 5483 ширхэг боршур тарааж анхаарал болгоомжтой аялаж зугаалахыг зөвлөлөө. Мөн Орхон гол, Гүннуурын эрэг дээр хүн, мал амьтан олноор цуглардаг усны түвшин өндөр, осолдох эрсдэлтэй газруудад анхруулах, сэрэмжлүүлэх самбар байршуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн Онцгой байдлын газрын [sea.nema.gov.mn](http://sea.nema.gov.mn) сайт, Онцгой байдлын газрын фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан ард иргэдэд "Усны осол, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх" сэрэмжлүүлэг мэдээ мэдээлэл зөвлөмжийг хүргэн ажиллаж байна.

### **Хоёр.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

"Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай" аймгийн Засаг даргын 2019 оны 05 тоот албан даалгаврыг гаргаж, холбогдох бэлтгэлийг хангаж ажиллах талаар сум, агентлагуудад чиглэл өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн Төрийн архивын дэргэдэх ББНШК-ын хурлыг 2 удаа зохион байгуулж, 25 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 10 хадгаламжийн нэгжийн 1970-2001 оны 1324 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 1121, хүний нэр 7700, байгууллагын нэр 38, газар зүйн нэр 221-ийг шивж, иргэд албан байгууллагад цаасан болон цахим хэлбэрээс 80, цалингийн тодорхойлолт 1, магадлагаа тодорхойлолт 28-ыг тус тус гаргаж өгч үйлчилсэн байна.

Аймгийн Цагдаагийн газраас "Сахилга, хариуцлагын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, "Орон нутгийн замын хөдөлгөөний соёл 2019" нэгдсэн арга хэмжээ, "Яараад яахав дээ" нөлөөллийн арга хэмжээг тус тус зохион байгуулан ажиллаж санамж, сэрэмжлүүлгийг тараасан.

Улсын бүртгэлийн хэлтэс тайлант сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 390, лавлагаа 6 бичиж, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 101, лавлагаа 26 олгож, иргэний бүртгэлийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд үзүүлж ажиллалаа. Үүнд:

- Төрсний бүртгэл – 159
- Гэрлэлтийн бүртгэл – 25
- Гэрлэлт цуцалсны бүртгэл – 8
- Эцэг тогтоолт – 39
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 3
- Нас баралт –53
- Нийт олгосон иргэний үнэмлэх – 388
- Шинээр олгосон иргэний үнэмлэх – 112
- Дахин олгосон иргэний үнэмлэх – 83
- Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 193
- Гадаад паспорт олголт – 52
- ОХУ-ын хавсралт – 2008
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн –193
- Хот доторх шилжилт хөдөлгөөн – 129 тус тус бүртгэгдсэн байна.

### **Гурав.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

Хүүхдийн тусламжийн 108 утсанд бие амх бодын 2, үйл хайхрах хүчирхийлэл-1 нийт 3 дуудлага ирсэн бөгөөд хамтарсан багийн хариу үйлчилгээг тухай бүрд нь үзүүлэн ажилласан. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн судалгааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллаж байна.

”Selenge cup-2019” спорт бүжгийн анхдугаар тэмцээнийг зохион байгуулж, 20 гаруй аймаг, дүүрэг, сумын 514 тамирчин оролцлоо.

### **Дөрөв. Хөдөө аж ахуйн талаар**

Төмс, хүнсний ногоо тариалагч иргэдийн тариалсан хүнсний ногоог худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Хүнс, хөдөө аж ахуйн газарт худалдааны талбай болон цэг гаргаж өгөх талаар хамтран ажиллах саналыг хүргүүлснээр Улаанбаатар хотын Хар хорин худалдааны төвд Сэлэнгэ аймгийн 7 ногоочин худалдаа эрхэлж байна. Өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд 30 гаруй тн хүнсний ногоо, 4 тн төмс хураан авч худалдан борлуулж байна.

2019 оны ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн техникийн судалдааг гарган ХХААХҮЯ-д хүргүүлсэн. Судалгаагаар 443 комбайн, 180 будаа цэвэрлэгч, 30 үр сортлогч, 139 будаа ачигч, 21 төмсний комбайн, 26 төмсний комбайн, 46 төмс ухагч ажиллахаас техникийн бэлэн байдал 70-80 хувьтай байна. Мөн хадлангийн 182 бага оврын трактор, 165 хадуур, 163 хадуур, 101 хаман боогч, 136 нуруулдагч, 35 морин хадуур, 75 морин тармуур ажиллахаас бэлтгэл ажил 85 хувьтай байна.

Уринш боловсруулалт аймгийн хэмжээнд нийт 117125 га талбайд уринш боловсруулалт хийснээс 64802 га механик 52323 га химийн уринш боловсруулсан байна.

7 дугаар сарын сүүлийн 10 хоногт үргэлжилэн орсон борооны улмаас ургац тааварлалтийн зам эвдэрч гэмтсэний улмаас үүссэн замыг засварлах санал, Цагааннуур сумын “Сэлэнгэ Тариа” ХХК-ний 1000 га газар мөндөрт цохиулсан тухай талбайн дүгнэлтийг тус тус ХХААХҮЯ-д хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд нийт хонь-33500, ямаа 17100, төлөв байдлын үнэлгээ хийж, үзлэгийн дүнд 15975 хонийг цөм сүргийн бүртгэлд авлаа.

2019 онд 726820 толгой эх мал төллөхөөс 7-р сарын 29-ны байдлаар 587024 эх мал төллөж, төл бойжилт 582647 буюу төллөх эх малын 81 хувь нь төллөсөн мэдээтэй байна.

Монгол улсын засгийн газрын дугаар 285 тогтоол Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах өвс тэжээлийн судалгааг гаргаж, аймгийн аюулгүй нөөцөд өвс 200тн, тэжээл 30 тн, бэлтгэхээр ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд Жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн Төсөл сонгон шалгаруулах аймгийн Дэд хорооны хурал 2019 оны 6 дугаар сарын 26-нд болж, “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн сонгон шалгаруулалт”-ын эх үүсвэрт багтаан тэргүүн ээлжинд санхүүжүүлэх 4 аж ахуйн нэгж, 15 иргэний 1,0 тэрбум төгрөгийн төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргын тоот захирамжаар батлууллаа.

МЭЭГ-ын даргын 2019 оны 01 сарын 07 ны өдрийн А/08 тоот тушаалын дагуу МЭҮН –ийн 45 ш баталгааны тэмдгийг 1,2 сая төгрөгөөр тод тамга компанид захиалан татан авч МЭҮН –дэд хүлээлгэн өгч мал эмнэлэг ариун цэвэрийн баталгааны тэмдэг

Шүлхий, бог малын мялзан өвчний халдварын өвчлөл тархалтыг судлах тандалтын шинжилгээнд мал амьтны эрүүл мэндийн албаны даргаар ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг Алтанбулаг, Шаамар, Мандал, Хөтөл сумдаас удирдамжын дагуу 8 багын 60 өрхийн үхэр-300, хонь-300, ямаа -300, цусны дээж авч, газар зүйн байршлыг гар утсанд суурилуулсан “Шүлхийн халдварын тандалт 2019 судалгаа” тусгай программ ашиглан өрх бүрээр мэдээллийг оруулсан.

Зүүнбүрэн сумаас ирсэн 5 эмгэгт эдийн дээжинд нян судлалын шинжилгээ, Зүүнбүрэн, Хүдэр, Мандал, Баянгол, Ерөө, Жавхлант, Хушаат, Орхонтуул, Сүхбаатар сумдаас сумаас ирсэн үнээ- 2708, бух-63, хуц-684, ухна-602, нийт 3994 мал, амьтанд бруцеллёз, 750 үнээнд лейкоз, сүрьеэ, бабезиоз өвчний шинжилгээг хийж халдваргүй болохыг тогтоож УМЭАЦТ-т баталгаажуулан зохих газарт хариуг хүргүүлэн ажилласан.

Шүлхий, бог малын мялзан өвчний халдварын өвчлөл тархалтыг тогтоох тандалтын шинжилгээнд удирдамжын дагуу Алтанбулаг, Шаамар, Мандал, Хөтөл сумдаас 8 багын 60 өрхийн үхэр-300, хонь-300, ямаа -300, цусны дээж авч, гар утсанд суурилуулсан “Шүлхийн халдварын тандалт 2019 судалгаа” тусгай программ ашиглан газар зүйн байршил, дээжийн бүртгэлийг өрх бүрээр оруулж мал эмнэлгийн лабораторит шинжилгээ хийх хүртэл -20<sup>0</sup> c-д хадгалж байна.

Бруцеллёзын шинжилгээг хийх, халдварлалтын түвшинг тогтоох удирдамжын дагуу “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Орхонтуул, Сант, Орхон, Сайхан, Баянгол, Мандал сумдаас буур-12, бух-989, хуц-1414, ухна-963 нийт 3378 цусны дээж цуглуулж ийлдсэн дээж бэлтгэн авч, гаргацтай дугаарлан бүртгэлжүүлж хүйтэн хэлхээний горимд тээвэрлэн аймгийн мал эмнэлгийн лабораторит шинжилгээ хийж эхлээд байна.

Сүхбаатар сумын худалдааны төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж буй 14360 кг үхрийн махны 97 дээж, 2135 кг хонины махны 89 дээж, 80 кг ямааны махны 4 дээж, 95 кг гахайн махны 1 дээж, 640 кг адууны махны -4 дээж, 70 л сүүний 4 дээж, 1200 л тарагны 3 дээж, 60 ш өндөгний 1 дээжинд магадлан шинжилгээ хийж баталгаажуулан ариун цэврийн гэрчилгээ олгосон.

Сумдад 230 өвөлжөө хашаа, 7 худаг уст цэгийн 49280 метр квадрат талбайд ариутгал халдаваргүйжүүлэлт хийж, төв зам дагуу болон гол, булаг шанданд унаж үхэж хорогдсон эзэн нь тодорхойгүй 35 ш малын сэг зэмийг цуглуулж халдваргүйжүүлэн устгасан.

### **Тав. Байгаль орчны чиглэлээр**

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын агаарын чанарын харуулын 7-р сарын хоёрдугаар арав хоногийн ажиглалтын дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн дундаж агууламж 0.001 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.002 мг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн дундаж агууламж 0.015 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.021 мг/м<sup>3</sup>, нийт тоосны дундаж агууламж 0.037 мг/м<sup>3</sup>, хамгийн их нь 0.051 мг/м<sup>3</sup>, агаар болон хөрсөн дээрхи цацрагийн түвшин фон түвшнээс даваагүй байна.

Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажлыг “Нью грийн форест” ХХК, “Мөнх ногоон жодоо” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан ба ажлын гүйцэтгэлийг 100 хувь өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэлийн тайланг хүлээн авч санхүүжилтийг олгож ажиллалаа. Мөн Алтанбулаг, Баянгол, Жавхлант, Орхон сумдын

нутагт цөлжилт, элсний нүүлтэд өртсөн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын эхлүүлсэн ажлын явц 70 хувьтай байна.

“Агнуур судлалын нийгэмлэг” ТББ нь аймгийн хэмжээнд хийгдэх ерөнхий агнуур зохион байгуулалт, менежмент төлөвлөгөө боловсруулах ажлыг 33,7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан. Бэлчир бүсийн сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газар байгуулах гэрээг байгуулан ажилласан.

Аймгийн хэмжээнд 2019 онд ахуйн зориулалтаар байгалийн ургамал түүж бэлтгэх хуваарийг сумдад хүргүүллээ. Мөн Аймгийн хэмжээнд байгалийн ургамал түүж бэлтгэх төлбөр хураамжийн 2020 оны орлогын төлөвлөгөө боловсруулан ажиллалаа. Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийг “Ойн ховор ашигт ургамлыг таних, зөв зохистой ашиглах нөхөн сэргээх арга” сэдэвт сургалтад хамруулсан. 5 булаг, шандын эхийг хамгаалах ажлын 80 хувийн санхүүжилтийг олгон ажиллалаа.

Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны “Хилийн мэргэжлийн хяналтын лабораторын барилга барих” төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийсэн. Дээрх төслийг нөхцөл боломжтой хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Эв- модны наадмыг 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдөр Алтанбулаг суманд зохион байгуулсан. Тус газар Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газартай хамтран гадаадын болон дотоодын төлөөлөгч, жуулчидад эв модны наадмын талаар мэдээлэл өгч, хоггүй цэвэрхэн баярлахыг уриалж ажилласан. ОХУ-ын Буриад Улсын болон дотоод гадаадын 90 гаруй төлөөлөгч арга хэмжээнд оролцсон. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран Ерөө сумын Ялбаг, Бэрлэг, Хавчиргана, Өлөнт гэх газруудаар ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтанд нийт 12 ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.

Хяналт шалгалтаар гэмт хэргийн шинжтэй 1, зөрчлийн шинжтэй 2 зөрчил илрүүлсэн бөгөөд холбогдох хууль хяналтын байгууллагууд газар дээр нь арга хэмжээ авлаа.

### **Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Баруунбүрэн сум:**

Сумын дүнгээр 2018 оны жилийн эцэст нийт 72567 толгой хээлтэгч тоологдсоноос 60053 толгой хээлтэгч төллөхөөс 40707 толгой нь төллөж 67,7%-тай байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Цөлжсөн элсний нүүлтэд өртсөн талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах”, “хуш,сибир жодооны” тарьц суулгацаар ойжуулалт хийх ажлын хүрээнд “Ойн Ирээдүй” мод үржүүлгийн газраас шинэсний 9500, жодооны 30, хушны 150 ширхэг тарьцыг авч, ойжуулалтын ажлыг хийсэн.

Сумын эрүүл мэндийн төвд тайлант сард амбулаторийн үзлэг 123 хийгдэж, 200 иргэн шинжилгээнд хамрагдаж, эмнэлэгт хэвтсэн 25 иргэнд үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Жирэмсний хяналтанд байгаа 26 , шинээр жирэмсний хяналтанд орсон 7 иргэн байгаа ба шаардлагатай шинжилгээгээ өгсөн эерэг гарсан тохиолдол илрээгүй байна. “Хэнд ч, хаана ч” уриан дор цусны донорын дэлхийн өдрийг тохиолдуулан сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэн, донорын үйлсийг сурталчилан олон нийтийн оролцоог алдаршуулах, талархал илэрхийлэх зорилготой аяныг зохион байгуулж, нийт 3 хүнийг донорын бүртгэлд элсүүлэн шинээр бүртгэсэн. “Цусны донор хүн та цусаа бэлэглэж амьдрал хайрлая” сэдвээр 6-р сарын 14-ны өдөр сургалт хийж, 30 иргэнд сурталчилгааны материал тараасан. Арга хэмжээнд оролцогчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж, хөгжилтэй асуулт, IQ-н болон донорын тухай мэдээлэлтэй холбоотой асуулт асууж, сэтгэн бодох чадвар, мэдлэг мэдээллийг шалгах, дүгнэх маягаар тэмцээнийг зохион явууллаа.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн шүдний эмч 6-р сарын 15, 16-нд хүүхдийн шүдийг оношилж, эмчилж, шүд угаах аргачлал, сургалт хийж 50 иргэнд хамрагдлаа.

Атар газар эзэмшсний 60-н жилийн ойд зориулан агрономич, аймгийн хурц арслан Л.Намжилдорж агсны нэрэмжит Баруун бүсийн шагайн харваан тэмцээнд 7 багийн нийт 80 гаруй харваачид ирж цэц мэргэнээ сорьлоо.

Мандал суманд болсон Мини волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд Ө.Энхтүвшин багштай өсвөрийн баг тамирчид амжилттай оролцож Э.Гансоронз, О.Мөнхтулга нар улсын аварга шалгаруулах тэмцээний эрх авсан. Мөн суманд болсон “Баруун бүсийн тэмцээн”-д гар бөмбөгийн дугуйлангийн хүүхдүүд оролцож, хүрэл медалийн эзэд боллоо.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого шийдвэр, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, иргэдийн дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, нийтийн биеийн тамираар хичээллүүлж нийтийн эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх, хүүхэд залуучуудыг чийрэгжүүлэх, дугуйн спортыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор “Дугуйтай өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулсан.

Тус сум нь 2019 онд 40 шинэ ажлын байр бий болгохоос 24 шинэ ажлын байранд зуучилж, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд хамрагдаж байгаа 4 өрхтэй гэрээ байгуулж, хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зорилтод бүлгийн болон хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авдаг 31 иргэнд 3 өдрийн сургалт зохион байгууллаа.

### **Баянгол сум:**

Даамын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 06 дугаар сарын 20-07 дугаар сарын 02-ны өдрүүдэд Узбекистан улсын Ташкент хотноо болж 13 орны 300-аад даамчин 7 насны ангилалд өрсөлдсөн уг тэмцээнд манай сумаас 2 даамчин оролцож 11-13 насны охидын Турк даамын төрөлд Н.Орхонцэцэг алтан медаль хүртэж Ази тивийн аварга боллоо. 5-7 насны ангилалд оролцсон Б.Маргад 6-р байрт шалгарсан амжилтыг гаргалаа.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг бүхий сумын хороо болон салбар хороог байгуулах тухай сумын Засаг даргын 2019 оны А/135 тоот захирамж гарч сумын хэмжээнд 2019 оны 06 дугаар сарын 29,30-ны өдрүүдэд тэмдэглэлээ. Баяр наадмыг зохион байгуулахад шаардагдах 5000,0 мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлээ. Баяр наадмын нээлтийн соёл урлагийн арга хэмжээнд 48 авьяастан оролцож 2500 хүн үзэж сонирхлоо. Баяр наадмыг угтан уламжлалт өв соёл, үндэсний дээл хувцас, эдлэл хэрэглэлээ сурталчлах зорилгоор “Дээлтэй Баянголчууд” баярын нэгдсэн жагсаалыг зохион байгуулж төр төсөв, аж ахуйн нэгжийн 22 байгууллага, 3 багийн 800 ажилтан албан хаагчид, иргэд амжилттай оролцлоо. “Дээлтэй Баянголчууд” наадамд Ерөнхий боловсролын сургууль, “Гэгээн Цолмон” ХХК, шагайн товчоо, Гонир багууд тэргүүлэн оролцож өргөмжлөл, гарын бэлгээр шагнууллаа. Баяр наадмын шоу арга хэмжээнд Алтан булаг сумын соёлын төв, “Мөнгөн Хараа” чуулгын уран бүтээлчид, сумын ардын авьяастнууд ая дуугаа өргөн 550 иргэд хамрагдлаа. Сэлэнгэ аймгийн баяр наадмын нээлтийн баярын нэгдсэн жагсаалд Баянгол сумын үе үеийн тариаланчдын төлөөлөн 11 хүнийг оролцуулсан.

Үндэсний их баяр наадам, ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадамд 6 насны морьдын уралдаанд нийт 271 морьд уралдаж наадамчин олноо баясгалаа.

Баяр наадмын амралт 2019 оны 07 дугаар сарын 11-15-ыг дуустал үргэлжлэж байгаатай холбогдуулан цагдаагийн хэсгийн жижүүрт нэмэгдлээр ажиллах төр, төсвийн байгууллагуудын хариуцлагатай жижүүрийн хуваарийг сумын Засаг даргын 2019 оны А/142 тоот захирамжаар баталж жижүүр хийсэн талаарх мэдээллийн аймгийн 70362171 утсанд тогтсон цаг хугацаанд мэдээлэн ажилласан.

Сумын эрүүл мэндийн төв амбулаториор нийт 487 иргэнийг үзлэгт хамруулан, дээд шатлалын эмнэлэгт 26 иргэнийг онош тодруулахаар илгээсэн. Хүлээн авах хэсгээр 382 иргэнд өдрийн эмчилгээг эмчийн заалтаар хийж үйлчилсэн.

Стационарт 43 хүнийг хэвтүүлэн 740,0 мян/төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулан, эмчилсэн.

Түргэн тусламжийн нийт 206 дуудлага хүлээн авснаас алсын 49, осол гэмтлийн 5 дуудлагад явж үйлчилсэн.

Монгол Улсын зэвсэгт хүчний Жанжин штаб, Америкийн Нэгдсэн Улсын тэнгисийн болон нисэх хүчний гэмтэл мэс засал, цэргийн эмнэлгийн яаралтай тусламжийн эмч нар хамтран, эмнэлгийн эмч ажилчид, иргэд нийт 70 хүнийг хамруулан, 2019 оны 07 дугаар сарын 23-аас 26-ны өдрүүдэд “Гамшгийн үеийн удирдлага, осол гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж” сэдэвтэй онол, дадлага хосолсон сургалтыг зохион байгуулан ажилласан.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Шөвөг яр 42377-44377, Галзуу 12399-8350, Гахайн мялзан 600-40, Дотрын халдварт хордлого 107738-107738, Сохор догол 89610-89610, Сахуу 2796-2796, Боом 171562-171562, Дуут 18853-18853 нийт 10 төрлийн вакцин тарилга хийгдэж байна.

Ариутгал халдваргүйжүүлэлт хийх аяны хүрээнд нийт 280 өрхийн 18400м<sup>2</sup> талбайд ариутгал хийсэн.

Тариалангийн тухай хууль зөрчин тариан талбайд мал оруулсан, ойролцоо буусан 2 малчинд мэдэгдэх хуудас өгч нүүлгэсэн.

Нийгмийн даатгалын санд нийт 63,4 сая төгрөгийн орлогоорж Сэлэнгэ аймаг нийгмийн даатгалын хэлтсээс 268,7 сая төгрөгийн санхүүжилт авч 3 төрлийн тэтгэвэрт нийт 268,7 сая төгрөгийг 828 иргэнд олгосон. Хөдөлмөрийн чадвар түр алдалтад 2 хүнд 770,7 мянган төгрөг, оршуулгын тэтгэмж 1 хүнд 1,0 сая төгрөг тус тус олгосон.

2019 онд орон нутгийн төсвийн орлогыг 199885.0 төгрөгөөр, зарлагыг 994783.1 мянган төгрөгөөр баталсан бөгөөд орон нутгийн орлого 475,5 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 7 сард 7.67 сая төгрөгийн орлого орсон.Төсвийн байгууллагуудын санхүүжилтийг 100 хувь олгоод байна.

2019 онд Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэхээр төлөвлөсөн Дулааны шугам засвар, гэрэлтүүлэг хийх 2 ажил дээр харьцуулалтын аргаар цахимаар тендер сонгон шалгаруулалт зохион байгуулснаас гэрэлтүүлгийн ажлынтендер шалгаруулалт амжилттай болсон. Дулааны шугам засварын тендер шалгаруулалт амжилтгүй болж харьцуулалтын аргаар дахин тендер шалгаруулалтыг зарлаад байна.

### **Сүхбаатар сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурал 1 удаа хуралдаж сумын ИТХ-д суудалтай намын санхүүжилтийг зарцуулах журам батлах тухай, Сүм, хийд байгуулах зөвшөөрөл болон зөвшөөрлийн хугацааг сунгах хүсэлтийг хэлэлцэх тухай, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай аймгийн ИТХ-ын 2017 оны 01 дүгээр сарын 31-ний 16-р тогтоолын хэрэгжилт, ОНХСангийн хөрөнгөөр хийсэн ажил үйлчилгээнд хяналт тавих зорилго бүхий багуудын хяналтын зөвлөлийг хэлэлцэн баталлаа.

Өрхийн тариалсан талбайн мэдээний программд 7 багийн төмс хүнсний ногоо тариалсан иргэдийн мэдээллийг шивж орууллаа. Хөдөө шаж ахуйн газраас өгсөн 5 төрлийн үрийн төмс, хүнсний ногоо тариалдаг 405 өрхөд хүлээлгэн өгсөн.7 дугаар сарын байдлаар мал төллөлт болон төл бойжилт 92.1 хувьтай байгаа ба үүнээс 621 гүү, 2030 үнээ, 2870 хонь, ямаа 3710 нийт 9231 эх мал төлөлсөн байна.

2019 онд Сүхбаатар суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дугуйн зам, явган хүний зам, хашлага солих ажил, Ган замын 7-р баг нийтийн эзэмшлийн орон сууцнуудын инженерийн шугам сүлжээний засварын ажлууд болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад хөндлөнгийн хяналтыг тавих

төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах сургалтад 8 багийн иргэдийн төлөөлөл, иргэдийн нийтийн хурлын дарга нарыг хамрууллаа.

Сумын тохижилт үйлчилгээний газарт хог тээврийн машин авах, сумын төвд “Хөх чулуут” дэлгүүрийн урд талбайн зам засварлах ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын удирдлага мэдээллийн шинэчилсэн систем “Фрийбаланс v7” програмаар орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 826.217.030.96 төгрөгийн 553 ширхэг гүйлгээг хянаж, баталгаажуулсан.

### **Хушаат сум:**

Ардын хувьсгалын 98 жилийн ой, Атар газар эзэмшсэний 60 жилийн ой, Хушаат сум байгуулагдсаны 32 жилийн ойн баяр өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлээ. Сумын баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 64 бөх үүнээс аймаг, сумын цолтой 32 бөх барилдаж Дархан-Уул аймгийн харьяат залуу бөх Э.Одхүү түрүүлж сумын заан цол хүртэн Хушаат сумын харьяат аймгийн начин Х.Чинбат үзүүлсэн. Сумын баяр наадмын үндэсний сурын харвааны төрөлд Дарха-Уул аймгийн харьяат Монгол Улсын Спортын мастер, аймгийн дэд мэргэн А.Түмэнжаргал түрүүлж Мандал сумын харьяат залуу харваач Х.Мөнхбаатар, Монгол Улсын хошой мэргэн, урианхай сурын спортын дэд мастер Г.Баянмөнх түрүүлж Зүүнбүрэн сумын залуу харваач Н.Баасанбат, Мандал сумын харьяат харваач Х.Мөнхбаатар нар удааллаа.

Суманд халдварт болон халдварт бус өвчнийг эрт илрүүлэх цогц үзлэг 2 дахь удаагаа явагдлаа. Үзлэгийн хүрээнд Улаанбаатар хотын Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн хамт олон, Улсын 3-р төв эмнэлэгийн чих хамар хоолойн эмч нар, Эх нялхасын Эрүүл Мэндийн төвийн нүдний эмч нар, аймгийн Эрүүл мэндийн Газрын 45 эмч, эмнэлэгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллан сумын иргэдийн эрт илрүүлэг үзлэг, оношлогоонд хамруулан үйлчиллээ.

### **Зүүнбүрэн сум:**

Сумын баяр наадмыг 2019 оны 07 дугаар сарын 01-нд зохион байгуулж Баатарын Отгонболд Урианхай сурын харвааны мэргэн, Хандын Байгальд Буриад сурын харвааны сумын мэргэн цол, үндэсний бахийн барилдаанд түрүүлсэн Отгонбаярын Эрхэмбаярт сумын заан цол тус тус олголоо. Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын нэрэмжит “Бэсрэг наадам”-ыг 2019 оны 07 дугаар сарын 22-нд зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1/542 тоот албан бичгийн хүрээнд Наадмын болон амралтын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 оны 07 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн 2019 оны 07 дугаар сарын 15-ныг дуусах хугацаанд сумын Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн А/131 тоот захирамжаар томилон ажиллууллаа. Эргүүл шалгалтын хугацаанд аялал, зугаалгаар явж байгаа иргэдэд хүүхдэдээ тавих хараа хяналтаа сайжруулан, аливаа гэмт хэрэг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлж, хог хаяхгүй байх талаар анхааруулж ажиллалаа. Эргүүл шалгалтын хугацаанд гэмт хэрэг зөрчил гараагүй болно.

2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн 5,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Соёл мэдээллийн төвийн үзэгчдийн сандлыг шинэчлэх, нэмэгдүүлэх ажлыг хийж, 102 ширхэг сандлаар нэмэгдүүллээ.

Сумын Эрүүл мэндийн төвд 21 иргэнийг хэвтүүлэн эмчилж, бмбулатороор 496 иргэнд үзлэг хийснээс өвчний учир 94, урьдчилан сэргийлэх үзлэгээр 354, дисдансерийн хяналтаар 39, гэрийн идэвхтэй эргэлтээр 14, дуудлагаар 25 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ үзүүллээ. 2019 оны 7 дугаар сарын байдлаар эхийн эндэгдэлгүй, 6 эхийг эхний сартайд жирэмсэний хяналтанд 100 хувь хамрууллаа. Мөн Хүүхдийн хяналт: Амьсгалын замын өвчнөөр 0-5 насны 2 хүүхдийг



хэвтүүлэн эмчилж, ээлжит товлолт вакцины хамрагдалт 1 хүртэлх насны хүүхдийг 100 хувь хамрууллаа.

2019 онд 65970 толгой мал, амьтаныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулахаас 48158 толгой малыг хамруулаад байна. Мал, амьтаны эрүүл мэндийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалтын дагуу хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Цагааннуур сумын малчин Ц.Баттулга, Бэлчир 2 дугаар багт отроор нүүж ирсэн тул мэдэгдэх хуудас өгч, холбогдох хуулийн дагуу шийдвэрлэлээ.

Мал сүргийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажилласнаар 11 тээврийн хэрэгсэлийг хамруулж, 21 үхэр, 29 хонь, 1180 кг гадууныхмах, 600 кг гүхрийнмах, 128 кг хонины, 18 кг ямааны маханд мал эмнэлгийн гарал үүсэл олгосон ба 21 мал, амьтанд олгосон мал эмнэлгийн гарал үүслийг баталгаажууан ажилласан. Мал эмнэлгийн ерөнхий газрын 2019 оны 01 тоот албан даалгавар, аймгийн мал эмнэлэгийн газрын даргын 96 тоот албан тоотыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 2019 оны 07 дугаар сарын 21-нээс эхлэн шинээр ирсэн зөөврийн мал угаалгын төхөөрөмжийг ашиглан, Бэлчир багийн 6 малчин өрхийн 3328 толгой бог малыг хамруулж эхлээд байна.

2019 онд 14 аж ахуйн нэгж, 232 иргэн 9056,5 га талбайд улаан буудай, 60 га-д овьёос, 2760 га-д тосны ургамал, 567,13 га-д тэжээлийн ургамал, 35,93 га-д төмс, 337,51 га-д хүнсний ногоо тус тус тариалсан ХАА-7 а,б маягтаар гаргаж хүргүүллээ.

### **Мандал сум:**

Тулгар төрийн 2228, Их Монгол Улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98, Мандал сум үүсэн байгуулагдсаны 95, Атар газар эзэмшсэний түүхт 60 жилийн ойн их баяр наадам өргөн дэлгэр сайхан боллоо. Баяр наадмын үндэсний бөхийн барилдаанд 96 бөх зодоглосноос аймгийн начин Т.Лхагвасүрэн түрүүлж, аймгийн начин Э.Бат-Эрдэнэ үзүүрлэлээ.

Монгол Улсын үндсэн хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаарх хуулийн төслийн хэлэлцүүлгийг Мандал суманд зохион байгуулж хэлэцүүлэгт Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, аймгийн Засаг даргын орлогч Б.Нарантуяа нар болон сумын удирдлагууд оролцон 400 гаруй иргэдээс санал хүсэлтийг хүлээн авлаа.

БНСУ-ын Кёнги аймагтай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Мандал сумын Нэгдсэн эмнэлэг болон Ерөө сумын Эрүүл мэндийн төвд иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн машиныг гардуулж өглөө.

Сумын ЗДТГ-ын барилгын гадна фасадыг орчин үеийн чанар, өнгө үзэмж сайтай метал хавтангаар шинэчилж, дээврийг бүрэн засварлаж ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна.

Улаанбаатар – Дархан чиглэлийн /А0401/ авто замын 130 км-ээс Мандал сум хүртэлх хуримтлуулах 30 км авто замын ажлын гүйцэтгэл 20%-тай үргэлжилж байна. Хотын төвийн доторх 6,5 км зам барилгын ажлыг 2019.07.19-ны өдрөөс эхлүүллээ.

“Билиг ДБ” сургуулийн “Билиг” хотхоны гадна шугам сүлжээг орон нутгийн өмчид шилжүүлэх албан хүсэлтийн дагуу Сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 13-ны өдрийн А/137 тоот захирамжаар ажлын хэсэг томилж, “Билиг” хотхоны гадна дулаан, цэвэр ус, бохирын шугам сүлжээг газар дээр нь үзэж шалган дүгнэлт үйлдэж, илэрсэн зөрчил дутагдлуудын арилгуулахаар хариу албан тоотыг хүргүүллээ. Мөн Баянхангайн 6-р багийн Депогийн хэсгийн шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа тул орон нутгийн өмчид шилжүүлэх инженерийн шугам сүлжээний жагсаалтад гадна цахилгааны шугам, хуваарилах байгууламжийг нэмж тусгаж оруулах шаардлагатай тухай “Билиг ДБ” сургуулийн захиргаатай хамтран тохиролцлоо.

Сумын шинэ суурьшлийн бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1, 2, 3, 4, 6-р багуудад 8 км орчим 6 киловольтын кабель шугам, 0.4 киловольтын агаарын шугам, 100-400 киловаттын хүчин чадалтай 16 ширхэг

трансформатор, 1 ширхэг хуваарилах байгууламж барих ажлыг эхлүүллээ. Ажлын гүйцэтгэл 70%-д хүрээд байна.

Ширхэнцэгийн 2-р багт Төрийн үйлчилгээний 2-р байрны зүүн талд 2 ширхэг 5 давхар 30 айлынорон сууц барих ажлыг эхлүүлээд байна. Ажлын гүйцэтгэл 10%-тай үргэлжилж байна. Минжийнхангайн 7-р багт Цагдаагийн албан хаагчдын 5 давхар 30 айлын орон сууцны барилгыг эхлүүллээ. Ажлын гүйцэтгэл 20%-тай үргэлжилж байна. Худалдааны гудамжинд “Аш” барилгын материалын дэлгүүрийн 2 давхар үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэл 15%-д хүрээд байна.

Минжийн хангай 2-р багийн Нарангийн гудамжинд “Жэй Си Ай” Дархан салбар байгууллагын тусламжаар 1 ширхэг гүний худаг барьж ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна. Тус гүний худаг нь ухаалаг худгийн систем суурилагдсанаар бүрэн ашиглалтанд орох юм.

Мал эмнэлгийн эрүүл мэндийн албаны дарга Х.Бейбет, мал эмнэлгийн улсын ахлах байцаагч Ц.Пүрэвдорж, Лабораторийн паразитын эмч Содбилэг нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гурван хоног малын гоц халдварт шүлхий болон бог малын мялзан өвчний дандалт судалгаанд 15 өрхийн 225 толгой малыг хамрууллаа.

### **Жавхлант сум:**

Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ой, Атар газар эзэмшсэний 60 жилийн ой, Жавлант сумын 42 жилийн ойн баяр наадмыг зохион байгууллаа. Баярын арга хэмжээг тохиолдуулан “Нэг баг-нэг агт” аяны хүрээнд хилийн цэргийн 0101 дүгээр ангид тус сумын Моностой 2-р багийн махлчин А.Билгүүн, П.Ганбат нар тус бүр нэг агт хандивлалаа. 7-р сард Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа, төр төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч болон албан хаагчдын шуурхай хурал 2 удаа боллоо.

Тайлант сард сумын эрүүл мэндийн төвд нийт 259 үзлэг хийгдснээс урьдчилан сэргийлэх үзлэг-80, амбулаторын үзлэг-132 хийж эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн, хөнгөлттэй жороор 60 иргэнд үйлчилж зөвлөгөө өгч ажилласан.

Төсвийн тухай хуулийн 8.9.1 дэх заалтын дагуу 7-р сарын 15-ны дотор улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг гарган тушаасан байх заалтын дагуу байгууллагуудын нягтлан бодогч нар 2019 оны эхний хагас жилийн тайланг гарган тушаалаа. Дунд сургууль, цэцэрлэг, соёлын төвийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа хуулийн хугацаанд нь тушаалаа. Орон нутгийн татварын орлого эхний хагас жилийн байдлаар 28509,7 мянган төгөрг орохоос 61481,7 мянган төгрөгийн орлого орж 215,6 хувийн биелэлттэй байна.

2019 оны 7-р сарын 05-06-ны өдрүүдэд сумын баяр наадмын өдрүүдэд суманд үйл ажиллагаа явуулж буй нийт 4 хүнсний дэлгүүр, 4 хуушуурын цэгүүдэд Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг хяналт шалгалт хийсэн. Тус хяналт шалгалтаар эрүүл ахуйн стандарт, хүнсний дэлгүүрүүдийн тусгай зөвшөөрөл, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг баримт, дээрх үйлчилгээний газруудын гаднах болон дотрох орчны эрүүл ахуйн стандарт, уг үйлчилгээний газрыг ажлуулж буй иргэдийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд орсон байдал зэрэгтэй танилцаж зөвлөн туслаж ажиллав.

### **Хүдэр сум:**

2019 оны 07-р сарын 10,11-ний өдрүүдэд үндэсний баяр наадмыг зохион байгууллаа. Баяр наадмаар аймгийн Засаг даргын жуухаар 2 иргэн, сумын Засаг даргын жуух бичгээр 5, аймгийн ИТХурлын хүндэт өргөмжлөлөөр 1, Хүндэт тэмдгээр 1 иргэн тус тус шагнагдлаа. Мөн Сэлмэн хайрхан овооны тахилгын баяр наадам, УИХ-ын гишүүн Н.Оюундарь иргэдтэй уулзалт, Тарвагатай 1-р баг Баянцагаан 2-р багийн өдөрлөг, Хүдэр сумын 47 жилийн үндэсний баяр наадамын арга хэмжээ, үдшийн цэнгүүн, 1989-1999 оны 6 дахь төгсөлт 20 жилийн уулзалт үдшийн цэнгүүн,

Улсын аварга малчин Цогнэмэхийн мялаалгын бэсрэг наадам, хэмжээ зохион байгуулагдан 5723 иргэн хамрагдсан байна

Сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна. Тайлант сард амбулаторийн 261 үзлэг хийж, 13 иргэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Жирэмсэн эхийн хяналтанд 31 эх байна. Жирэмсний хяналтанд байгаа эхчүүдээс 18 эхэд гэр бүлийн хүний хамт “Жирэмсний аюултай шинж”, “Жирэмсний хоололт” сэдвүүдээр зөвөлгөөг өгөн ажиллаж байна. Дархлаажуулалтад хамрагдвал зохих 51, явуулын түр оршин суугчдын 2 хүүхдийг тус тус дархлаажуулалтад хамрууллаа. Мөн товлол буюу заавал хийх дархлаажуулалтад буюу Саа өвчний эсрэг уудаг вакцин 21, Тавт вакцин 21, Улаан бурхан гахайн хавдар улаануудын эсрэг вакцин 13, ПЭВ-5, ИСВ-8, Гепатит “А” вакцин 12 хүүхэд хамрагдсан байна.

Монгол улсын Ойн тухай хууль болон аймаг сумын ИТХурлын тогтоол, Засаг даргын захирамж бусад дүрэм журмыг өдөр тутамын ажилдаа мөрдлөг болгон ажиллалаа. Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 77 тоот тогтоолын дагуу нэмэлт мод бэлтгэх хуваарийн судалгаа болон орон нутгийн иргэдийн хэрэгцээнд хуваарлисан уламжлалт бүтээгдэхүүн, түлээний мод бэлтгэх газар, Шаамар сумын хэрэглээ түлээний мод бэлтгэх газрын нөөцийн судалгааг гаргаж сумын ИТХурлаар хэлэлцүүлэн батлууллаа. Үүний дагуу сумын Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 99 тоот захирамж гарч мод бэлтгэлийн талбай тусгаарлалтыг Шанд, Хэрц, Янгаахайн даваа, Сайдын ам, Хотго гол нэртэй газар 55 га талбайд хийж гүйцэтгэн аж ахуй нэгж байгууллага мод бэлтгэлийн үйл ажиллагаа явагдаж байна. Ойн санг гэрээгээр эзэмшигч ойн мэргэжлийн байгууллагуудад Ойн тухай хууль болон ИТХурлын тогтоол шийдвэр, мод бэлтгэлийн технологи, зааварчилгаатай холбоотой 2 удаагийн уулзалт ярилцлагыг зохион байгуулж мэргэжил аргагүйгээр хангаж ажиллалаа.

БОАЖЯамнаас зарласан Цэвэрхэн наадацгаая аяны хүрээнд хулдаасан хэвлэл, стикер хэвлүүлэн, явуулын хогийн цэгийг ажиллуулан иргэд олон нийтэд уриалан зохион байгуулж ажиллалаа.

### **Шаамар сум:**

Ардын хувьсгалын ой, сумын баяр наадмыг 7-р сарын 06-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Баяр наадмын бай шагналыг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын дагуу жишиг хэмжээг олгож, төсвийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэсэн.

Сумын 2020 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөрийн саналыг танилцуулах, 2019 оны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн гүйцэтгэл, ажлын тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлууллаа. Үүнд: ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд орон нутагт хэрэгжүүлэх саналыг хуулийн хугацаанд багийн Засаг дарга, ИНХ-ын дарга, Тэргүүлэгчид 1-р улиралд багтаан саналын хуудсаар хүлээн авч нэгтгэн 2019 оны 05-р сард багтаан хэлэлцүүлж, жагсаалтыг нэгтгэн сумын ажлын хэсэг хүлээлгэн өгсөн. Үүнд: баг тус бүрээс “Хогийн машин, мал угаах ванн, хүүхдийн тоглоомын талбай зэргийг 108 сая төгрөгийн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр ирүүлснийг хэлэлцүүлэн батлуулсан.

Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй ХАА-н бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг дэмжих техник туслалцааны төслөөс Зөгийн аж ахуйд мал эмнэлэгийн үйлчилгээг хэрхэн зохион байгуулах тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуй, чанарт хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах сэдэвт шаталсан сургалтад хамрагдаж, Зөгийн өвчгөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, зөгийн бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах гэрчилгээ авсан.

Япон Улсын Шизоука мужаас Сэлэнгэ аймагт ажиллаж буй 4 иргэнд үр тариа, хүлэмжийн аж ахуйн үйл ажиллагааг танилцуулах ажлыгн аймгийн ХХАА-н газартай хамтран зохион байгуулж, “Ундрагч” ХХК-ий үр тариа, Охиндий 2-р багийн иргэн Д.Энхтөрийн хүлэмжийн үйл ажиллагаатай танилцуулав.

2019 оны хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь Санхүүгийн албаны даргаар хянуулан аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. Хагас жилийн байдлаар төсвийн гүйцэтгэлийн хувиар нь аймгийн Санхүүгийн дэмжлэгээс 525161,01 төгрөгийн санхүүжилт авахаас 469596,51 төгрөгийн санхүүжилт авч, санхүүгийн дэмжлэг 90 хувийн гүйцэтгэлтэй. Орон нутгийн ерөнхий орлогын төлөвлөгөө 49,074,500 төвлөрүүлэхээс 185,893,41 орлого төвлөрүүлсэн.

### **Түшиг сүм:**

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 89 тоот тогтоолоор Монгол Улсын тулгар төр байгуулагдсаны 2228 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 813 жил, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн их, сумын их баяр наадмыг 2019 оны 07 дугаар сарын 09-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Баяр наадмын хүчит бөхийн барилдаанд О.Сундуй түрүүлж “Сумын заан” цол олгож, залуу бөх Б.Болдбаатар үзүүрлэлээ. Баяр наадмын өдөрт хурдан морьдын уралдаан, шагай харваа, сур харвааны тэмцээнийг явуулж, партизан Сүхийн хүү хурандаа Баатарын нэрэмжит “Шатарын тэмцээн”-ийг 3 насны ангилалаар явуулж нийт 60 гаруй иргэд оролцлоо.

Атар газар эзэмшсэний 60 жилийг ойг угтаж “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор Д.Батчулуун, Б.Өлзийбат, “Хөдөө аж ахуйн тэргүүний ажилтан”-аар Д.Нацагдорж нар шагнагдсан. Мөн “Улаан Загалмайн нийгэмлэгийн 80 жилийн ойг тэмдэг”-ээр Онцгой гишүүд, хүмүүнлэгийн үйлсэд идэвхи зүтгэлтэй ажилаж буй нийт 12 иргэнийг шагналаа.

Сумын 11 малчин өрхийн 3510 хээлтэгч, 90 хээлтүүлэгч, 3600 толгой хонин сүрэгт үзлэг ангилалт хийж, ашиг шимийн гарц чанар, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Сумын хэмжээнд нийт 87 малчин өрх 13,0 мян тн хонины ноос тушаалаа.

Сумын Эрүүл мэндийн төвд 158 иргэнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон гэрийн идэвхитэй эргэлтэд хамруулж, түргэн тусламжийн 39 дуудлага үүнээс алсын 7, ойрын 32 дуудлагад үйлчиллээ. Тайлант сард 1 эх төрж, одоогоор жирэмсний хяналтанд 4 эхийг шинээр авч, эхний 3 сартай хяналт 1 буюу 25% бөгөөд нийт 19 эх хяналтанд байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулж буй цээжний хөндийн эмгэг илрүүлэг үзлэгт 402 хүнээс, хавьтлын 167 хүнээс 112 буюу 67%, эрсдэл бүлгийн 235 хүнээс 223 буюу 94,8%, ойрын хавьтлын 37 хүүхдэд сорил тавьсан бөгөөд эрсдэлт илрэл гараагүй байна.

ХЯНАСАН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Б.БОЛОРЗУЛ

БОЛОВСРУУЛСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ш.ЭНХМАА